



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Богд сумын Сум дундын эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** БНА-2021/166/СТА-ТШЗ

Баянхонгор 2021 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576      Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням Утас: 88089024      Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор:              Ж.Өсөхбаяр Утас: 99890393      Цахим хаяг: usukhbayarj@audit.gov.mn Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>
-----------------------	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт /Эх хувь/.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	8
3.Аудитын тайлан .....	9
3.1. Ерөнхий зүйл .....	9
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	9
3.4. Материаллаг байдал .....	10
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	10
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	11
3.7. Шилэн дансны мэдээлэл .....	12
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	13
3.9. Аудитын илрүүлэлт .....	13
Залруулсан алдаа .....	13
Аудитын зөвлөмж .....	13
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	13
4. Менежментийн захидал.....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	15



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584  
E-mail; bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР АЙМГИЙН БОГД Г  
СУМЫН СУМ ДУНДЫН  
ЭМНЭЛГИЙН ЭРХЛЭГЧ  
А.ЦЭЦЭГБАДАМ ТАНАА

2021.02.03 № 2/11  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г **Аудитын гэрчилгээ** Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Богд сумын Сум дундын эмнэлгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баянхонгор аймгийн Богд сумын Сум дундын эмнэлгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Богд сумын Сум дундын эмнэлгийн 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод

2021 А4 ТООТ

• 005020853

хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

### **Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР Б.МӨНХБАТ



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>36,609,671.00</b>	<b>59,785,273.00</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	36,609,671.00	59,785,273.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	27,555,521.00	48,049,253.00
35110	Тусгай зориулалттай материал	25,053,356.00	27,253,025.00
35130	Эм боох материал	2,502,165.00	20,796,228.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	9,054,150.00	11,736,020.00
35410	Бичиг хэргийн материал	2,232,400.00	2,755,220.00
35420	Аж ахуйн материал	3,686,050.00	5,563,000.00
35440	Түлш, шатах тослох материал	142,500.00	800,000.00
35460	Хүнсний материал	2,993,200.00	2,617,800.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>953,494,466.09</b>	<b>958,779,023.28</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	953,494,466.09	958,779,023.28
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	931,286,466.09	936,571,023.28
39201	Барилга, байгууламж, орон сууц	927,311,112.00	949,428,944.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-59,852,910.32	-75,571,317.20
39203	Авто-тээврийн хэрэгсэл	56,260,000.00	56,260,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-35,858,749.92	-45,423,749.88
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	184,982,921.00	204,048,896.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-159,513,518.35	-167,569,719.08
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	38,929,920.00	39,529,920.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,972,308.32	-24,131,950.56
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	22,208,000.00	22,208,000.00
39301	Програм хангамж	790,000.00	790,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-790,000.00	-790,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	22,208,000.00	22,208,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>990,104,137.09</b>	<b>1,018,564,296.28</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>00.00</b>	<b>2,255,218.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	00.00	2,255,218.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	00.00	2,255,218.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	2,255,218.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>990,104,137.09</b>	<b>1,016,309,078.28</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	990,104,137.09	1,016,309,078.28
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	494,889,919.00	494,889,919.00
51101	Өмч: - төрийн	494,889,919.00	494,889,919.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-101,902,829.83	-75,697,888.64
51210	Өмнөх үеийн үр дүн	-101,902,829.83	-101,902,829.83
51220	Тайланг үеийн үр дүн	00.00	26,204,941.19
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	597,117,047.92	597,117,047.92
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>990,104,137.09</b>	<b>1,018,564,296.28</b>

**Богд сумын Сум дундын эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>586,932,310.00</b>	<b>733,590,829.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>9,403,300.00</b>	<b>52,000,133.00</b>
120	Нийтлэг татварын бус орлого	1,103,300.00	14,958,326.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,103,300.00	14,958,326.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,103,300.00	14,958,326.00
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>8,300,000.00</b>	<b>37,041,807.00</b>
122001	Хандив тусламж /дотоод/	8,300,000.00	37,041,807.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>577,529,010.00</b>	<b>681,590,696.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>531,191,600.00</b>	<b>610,246,500.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	531,191,600.00	610,246,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>39,400.00</b>	<b>12,414,832.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	12,183,432.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	39,400.00	231,400.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>46,298,010.00</b>	<b>58,929,364.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	46,298,010.00	58,929,364.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>608,928,928.32</b>	<b>707,385,887.81</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>608,928,928.32</b>	<b>707,385,887.81</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>604,503,149.32</b>	<b>693,627,653.81</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>388,561,733.00</b>	<b>461,377,716.00</b>
210101	Үндсэн цалин	388,561,733.00	461,377,716.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>48,044,563.00</b>	<b>56,403,113.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	44,614,764.00	56,403,113.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,429,799.00	00.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>43,656,927.00</b>	<b>44,499,324.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,208,169.00	3,908,066.00
210302	Тулц, халаалт	40,448,758.00	40,591,258.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>24,618,133.00</b>	<b>23,337,978.00</b>
210401	Бичиг хэрэг	4,101,800.00	4,471,820.00
210402	Тээвэр, шатахуун	13,997,200.00	13,793,110.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	253,248.00	261,383.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,800,550.00	3,689,750.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,465,335.00	1,121,915.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>51,175,342.00</b>	<b>60,870,597.00</b>
210501	Эм, бэздмэл, эмнэлгийн хэрэгсэл	40,422,192.00	49,441,697.00
210502	Хоол, хүнс	7,845,150.00	9,275,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,908,000.00	2,153,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,470,100.00</b>	<b>3,484,000.00</b>
210604	Урсгал засвар	4,470,100.00	3,484,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>886,000.00</b>	<b>1,141,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	886,000.00	1,141,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,338,280.00</b>	<b>3,978,316.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	50,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	920,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	460,740.00	455,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	130,800.00	147,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,980,000.00	1,980,000.00
210807	Газрын төлбөр	111,040.00	110,916.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	300,700.00	258,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>39,752,071.32</b>	<b>38,535,609.81</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,164,580.00	2,036,360.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	36,587,491.32	36,499,249.81
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,425,779.00</b>	<b>13,758,234.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>680,000.00</b>	<b>12,863,432.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	12,183,432.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	680,000.00	680,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>39,400.00</b>	<b>894,802.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	39,400.00	894,802.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>3,706,379.00</b>	<b>00.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,706,379.00	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-21,996,618.32</b>	<b>26,204,941.19</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>654,915.27</b>	<b>00.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	654,915.27	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-654,915.27</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-22,651,533.59</b>	<b>26,204,941.19</b>

**Богд сумын Сум дундын эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>577,529,010.00</b>	<b>681,590,696.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>577,529,010.00</b>	<b>681,590,696.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	531,191,600.00	610,246,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	531,191,600.00	610,246,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	39,400.00	12,414,832.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	12,183,432.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	39,400.00	231,400.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	46,298,010.00	58,929,364.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	46,298,010.00	58,929,364.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>577,529,010.00</b>	<b>676,848,696.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>577,529,010.00</b>	<b>676,848,696.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>573,103,231.00</b>	<b>663,090,462.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	388,561,733.00	461,005,800.00
210101	Үндсэн цалин	257,935,369.00	268,901,817.48
210102	Нэмэгдэл	95,991,364.00	143,489,983.96
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,347,000.00	7,854,000.17
210104	Урамшуулал	27,288,000.00	40,759,998.39
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	48,044,563.00	56,775,029.00
210201	Тэтгэврийн даатгал	32,785,675.00	38,334,829.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,840,880.00	4,610,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,073,919.00	3,688,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	695,225.00	922,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,648,864.00	9,220,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	43,716,927.00	44,356,824.00
210301	Гэрэл, цахилгаан	3,268,169.00	3,908,066.00
210302	Түлш, халаалт	40,448,758.00	40,448,758.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	20,544,348.00	20,212,493.00
210401	Бичиг хэрэг	1,577,200.00	800,000.00
210402	Тээвэр, шатахуун	13,997,200.00	13,793,110.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	325,048.00	310,883.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,196,900.00	3,288,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,448,000.00	2,020,300.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	49,072,000.00	63,812,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	38,637,000.00	53,089,700.00
210502	Хоол, хүнс	8,455,000.00	8,900,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,980,000.00	1,822,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	13,200,000.00	4,418,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,200,000.00	985,000.00
210602	Тавилга	3,000,000.00	00.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	3,433,100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	886,000.00	1,141,000.00
210702	Дотоод албан томилолт	886,000.00	1,141,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,127,680.00	5,369,016.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	221,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	1,020,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	454,000.00	455,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	147,800.00	147,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,980,000.00	1,980,000.00
210807	Газрын төлбөр	92,100.00	110,916.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	258,000.00	258,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	840,780.00	1,120,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	4,949,980.00	6,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,949,980.00	6,000,000.00

**Богд сумын Сум дундын эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,425,779.00</b>	<b>13,758,234.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	680,000.00	12,863,432.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	12,183,432.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	680,000.00	680,000.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	39,400.00	894,802.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	39,400.00	894,802.00
2135	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	3,706,379.00	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,706,379.00	00.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>4,742,000.00</b>
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>4,742,000.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>4,742,000.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	00.00	4,742,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	4,742,000.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>-4,742,000.00</b>
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
					Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	472,681,919.00	300,167,049.00	18,381,365.96	791,230,333.96
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	472,681,919.00	300,167,049.00	18,381,365.96	791,230,333.96
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-45,770,992.46	-45,770,992.46
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	494,889,919.00	597,117,047.92	-101,902,829.83	990,104,137.09
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	494,889,919.00	597,117,047.92	-101,902,829.83	990,104,137.09
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	494,889,919.00	597,117,047.92	-101,902,829.83	990,104,137.09
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	26,204,941.19	26,204,941.19
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	494,889,919.00	597,117,047.92	-75,697,888.64	1,016,309,078.28

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	669,246,900.00	668,291,062.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	669,246,900.00	668,291,062.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	668,566,900.00	667,611,062.00
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	461,005,800.00	461,005,800.00
210101	Үндсэн цалин	271,732,900.00	268,901,817.48
210102	Нэмэгдэл	140,658,900.00	143,489,983.96
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,854,000.00	7,854,000.17
210104	Урамшуулал	40,760,000.00	40,759,998.39
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	57,625,700.00	56,775,029.00
210201	Тэтгэврийн даатгал	39,185,500.00	38,334,829.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,610,100.00	4,610,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,688,000.00	3,688,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	922,000.00	922,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,220,100.00	9,220,100.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	44,461,900.00	44,356,824.00
210301	Гэрэл, цахилгаан	3,977,500.00	3,908,066.00
210302	Түлш, халаалт	40,484,400.00	40,448,758.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	20,212,500.00	20,212,493.00
210401	Бичиг хэрэг	800,000.00	800,000.00
210402	Тээвэр, шатахуун	14,866,300.00	13,793,110.00
210403	Шуудан, холбоо, ингернэтийн төлбөр	346,200.00	310,883.00

**Богд сумын Сум дундын эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,200,000.00	3,288,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.00	2,020,300.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>65,062,200.00</b>	<b>65,062,200.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	55,182,200.00	54,339,700.00
210502	Хоол, хүнс	7,900,000.00	8,900,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,980,000.00	1,822,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>7,910,100.00</b>	<b>7,910,100.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,410,100.00	4,410,100.00
210604	Урсгал засвар	3,500,000.00	3,500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,141,000.00</b>	<b>1,141,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,141,000.00	1,141,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,147,700.00</b>	<b>5,147,616.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,020,000.00	1,020,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	455,900.00	455,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	147,800.00	147,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,980,000.00	1,980,000.00
210807	Газрын төлбөр	111,000.00	110,916.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	258,000.00	258,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,120,000.00	1,120,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>6000000.00</b>	<b>6000000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,000,000.00	6,000,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>680000.00</b>	<b>680000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>680,000.00</b>	<b>680,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	680,000.00	680,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>669,246,900.00</b>	<b>668,291,062.00</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>610,246,500.00</b>	<b>609,361,698.00</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	610,246,500.00	609,361,698.00
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>59,000,400.00</b>	<b>58,929,364.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	59,000,400.00	58,929,364.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>34.00</b>	<b>33.00</b>
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	28.00	27.00
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00
<b>64</b>	<b>ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО</b>	<b>00.00</b>	<b>6,499.00</b>
640001	Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо	00.00	390.00
640002	Улсын эмнэлгийн амбулатороор эмчлүүлэгсдийн тоо	00.00	6,109.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>34.00</b>	<b>33.00</b>
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	23.00	22.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11.00	11.00

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл /төгрөгөөр/
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>39400.00</b>	<b>12,414,832.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>39400.00</b>	<b>12,414,832.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		221,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		221,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		221,400.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>39400.00</b>	<b>12193432.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>39400.00</b>	<b>12,193,432.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		12,183,432.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	39400.00	10,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>39400.00</b>	<b>12414832.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>39400.00</b>	<b>12,414,832.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		12,183,432.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	39400.00	231,400.00
	Мөнгө, түүнгэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		

### **3.Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Богд сумын Сум дундын эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Богд сумын Сум дундын эмнэлгийн эрхлэгч эмч А.Цэцэгбадам танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 26-аас 2021 оны 01 дүгээр сарын 29-ний хооронд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр хариуцаж хэрэгжүүлэв.

Богд сумын Сум дундын эмнэлэг нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 08 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Богд сумын Сум дундын эмнэлгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрүүл мэнд, амбулаторийн тусламж үйлчилгээ
- Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ
- Оношилгоо шинжилгээ
- Өдрийн эмчилгээ
- Хөнгөвчлөх эмчилгээ
- Түргэн тусламжийн үйлчилгээ
- Сэргээн засах уламжлалт эмчилгээ

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Богд сумын Сум дундын эмнэлгийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Эрүүл мэндийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд харьяа орон нутаг дахь Богд сумын Сум дундын эмнэлгийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны 3 дугаар улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардал 506147.0 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 10122.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 707385.9 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 14147.7 мянган төгрөгөөр тооцов.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Богд сумын Сум дундын эмнэлгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1018564,3 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 28460.2 мянган төгрөгөөр буюу 2.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	36,609.7	59,785.3	23,175.6
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	36,609.7	59,785.3	23,175.6
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	953,494.5	958,779.0	5,284.6
Үндсэн хөрөнгө	1,230,482.0	1,272,265.8	41,783.8
Хуримтлагдсан элэгдэл	(276,987.5)	(313,486.7)	(36,499.2)
<b>Нийт хөрөнгө</b>	990,104.1	1,018,564.3	28,460.2
Өр төлбөр	-	2,255.2	2,255.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	990,104.1	1,016,309.1	26,204.9
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	990,104.1	1,018,564.3	28,460.2

Бараа материалын дансны үлдэгдэл 59785.3 мянган төгрөг болж 23175.6 мянган төгрөгөөр өссөн нь эм, эмнэлгийн хэрэгслийн дансны үлдэгдэл өмнөх оноос 18294.1 мянган төгрөгөөр нэмэгдэж цар тахлын үед бэлэн байдлыг хангах зорилгоор 10565.8 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй, 6901.4 мянган төгрөгийн эм эмнэлгийн хэрэгслийг төсвийн хөрөнгөөр худалдан авч нөөцөлсөн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1272265.8 мянган төгрөг болж 41783.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 4742.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хандив тусламжаар 32041.8 мянга төгрөгийн хөрөнгө бүртгэж, 5000.0 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 18117.8 мянга, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 4000,0 мянган төгрөг, урсгал төсвийн худалдан авалтаар 4742.0 мянган төгрөг, аймгийн Нэгдсэн эмнэлгээс 5000.0 мянга, Эрүүл мэндийн газраас 8824.0 мянган төгрөгийн үнэ төлбөргүй шилжиж ирсэн 1100.0 мянган төгрөгийн хөрөнгө хандив тусламжаар нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1016309.1 мянган төгрөг болж 26204.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 26204.9 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 733590.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 146658.5 мянган төгрөгөөр буюу 24.9 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан төсөвт байгууллагын өөрийн орлого, тусламж санхүүжилтийн орлого байна. Төсөв байгууллагын өөрийн орлого өмнөх оноос 13855.0 мянган төгрөгөөр өссөн нь төлбөргүй хүлээж авсан орлого нэмэгдсэнтэй, тусламж санхүүжилтийн орлого 104061.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт 79054.9 мянга, Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт 12631.3 мянган төгрөгөөр нэмэгдэж, нэмэлт санхүүжилтийн дансанд ажилчдын 5 жилийн тэтгэмж 12183.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Нийт зардал 707385.9 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 98457.0 мянган төгрөгөөр буюу 16.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, норматив зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал нэмэгдсэнтэй холбоотой байна

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 680097.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 680097.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 10850.3 мянган төгрөгөөр бууруулж 669246.9 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 669246.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 610246.5 мянган төгрөгийг улсын төсвөөс 59000.4 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 610246.5 мянга, эрүүл мэндийн даатгалын сангаас 58929.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 669175.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 668291.1 мянган төгрөгийг зарцуулж 884.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 668291.1 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 850.7 мянга, байр ашиглалттай холбоотой тогтол зардлыг 105.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 71602 хөтөлбөрийн 80101 арга хэмжээ 955.8 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

**Богд сумын Сум дундын эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дун	Хувь
ХӨТӨЛБӨР 71602	-	-	-	-
АРГА ХЭМЖЭЭ 80101	-	-	-	-
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	662,566,900.00	661,611,062.00	955,838.00	99.86
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	662,566,900.00	661,611,062.00	955,838.00	99.86
Бараа, үйлчилгээний зардал	662,566,900.00	661,611,062.00	955,838.00	99.86
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	461,005,800.00	461,005,800.00	-	100.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,625,700.00	56,775,029.00	850,671.00	98.52
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,461,900.00	44,356,824.00	105,076.00	99.76
Хангамж, бараа материалын зардал	20,212,500.00	20,212,493.00	7.00	100.00
Нормативт зардал	65,062,200.00	65,062,200.00	-	100.00
Эд хогшил худалдан авах	7,910,100.00	7,910,100.00	-	100.00
Томилолт, зочны зардал	1,141,000.00	1,141,000.00	-	100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	5,147,700.00	5,147,616.00	84.00	100.00
АРГА ХЭМЖЭЭ 80802	-	-	-	-
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	680,000.00	680,000.00	-	100.00
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	680,000.00	680,000.00	-	100.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	680,000.00	680,000.00	-	100.00
Бусад урсгал шилжүүлэг	680,000.00	680,000.00	-	100.00
АРГА ХЭМЖЭЭ 83112	-	-	-	-
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,000,000.00	6,000,000.00	-	100.00
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	6,000,000.00	6,000,000.00	-	100.00
Бараа, үйлчилгээний зардал	6,000,000.00	6,000,000.00	-	100.00
Бараа үйлчилгээний бусад зардал	6,000,000.00	6,000,000.00	-	100.00
Бараа үйлчилгээний бусад зардал	6,000,000.00	6,000,000.00	-	100.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	669,246,900.00	668,291,062.00	955,838.00	99.86

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Эрүүл мэндийн газраас ажилчдын 5 жилийн тэтгэмжийн санхүүжилт 12183.4 мянган төгрөг, сорьц тээврийн хөлс 221.4 мянга, ариутгалын хөлс 10.0 мянга, нийт 12414.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс ажилчдын 5 жилийн тэтгэмжид 12183.4 мянга, сорьц тээвэр, аж ахуйн материалын зардалд 504.5 мянга нийт 12404.8 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 10.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 161 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь байршуулсан байна.

Д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9		2
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	4		
4	Сар бүр	5	46	46		
5	Тухай бүр	8	96	96		
	Нийт	29	161	159	0	2

### 3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх онд тус байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлж аудит хийгдээгүй болно.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 7287.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4510.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 2776.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Тендерийн эм, эмнэлгийн хэрэгслийг ханган нийлүүлэгч аж ахуйн нэгжээс Эрүүл мэндийн газраар дамжуулан худалдан авсан 2255218 төгрөгөөр эмийг санхүүгийн тайланд үлдэгдлээр байхад бүртгээгүй ба үүнтэй холбогдуулан тухайн байгууллагад төлөх эмийн үнийг төлөөгүй өглөгийг тайланд тусгаагүй байна. Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд 2255218 төгрөгийг бараа материалын орлогоор мөн өглөгөөр тайланд тусгаж залруулга хийв.

#### Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 2776.9 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 74 дүгээр тогтоолоор тус байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 1980 онд ашиглалтад орсон эмнэлгийн агуулах, угаалга, ариутгалын барилгын зүүн тийшээ харсан 3 өрөөг холбогдох мэргэжлийн байгууллагаар хэмжилт хийлгүүлж тус сумын иргэн Ц.Эрдэнэцэцэгт хүлээлгэн өгч данс бүртгэлээс хасах шийдвэр гарсан ч боловч тус шийдвэрийг хэрэгжүүлээгүй, мөн сумын Засаг даргын 2014 оны 53 дугаар захирамжаар тус барилгад ногдох 450 м<sup>2</sup> талбайг хассан шийдвэр гарсан байна.

Иймд мэргэжлийн байгууллагын хэмжилт хийлгэсний дараа барилгын дансны үнэ болон газрын хэмжээнд орсон өөрчлөлтийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 1. **Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал**

- 1.1. **Илрүүлэлт:** Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана." гэсэн заалтыг зөрчсөн.
- 1.2. **Эрсдэл:** Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, батлаагүй байгаа нь тухайн байгууллагын онцлог, үйл ажиллагаатай холбоотой ажил гүйлгээг бүртгэхэд хууль, тогтоомж зөрчигдөх.
- 1.3. **Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана." гэсэн заалтыг хэрэгжүүлж Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж үйл ажиллагаандаа мөрдүүлэх.
- 1.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

## **2. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал**

**2.1. Илрүүлэлт:** Хүнсний зардлыг анхан шатны баримтаас тулган шалгахад тайлант онд 2993.2 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 8900,0 мянган төгрөгийн хүнс худалдан авч 9275.4 мянган төгрөг хүнс зарцуулан оны эцэст 2617.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Энэ үлдэгдэл нь цаг агаар, цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан 2020 оны 11 дүгээр сард 2405.0 мянган төгрөгөөр 370 кг үхрийн мах худалдан авсантай холбоотой ч Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

**2.2. Эрсдэл:** Махыг их хэмжээгээр авч нөөцөлсөн нь хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал хангахгүй байх.

**2.3. Өгсөн зөвлөмж** Хүнсний материалыг их хэмжээгээр нөөцөлж хүнсний бүтээгдэхүүний чанар байдалд өөрчлөлт орох, аюулгүй байдал хангахгүй байх эрсдэлийг үүсгэхгүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтыг мөрдөж ажиллах

**2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

## **3. Зардлын данстай холбоотой асуудал**

**3.1. Илрүүлэлт:** Цалингийн зардалд 461377,7 мянга, НДШ-ийн зардалд 56403,1 мянган төгрөг зарцуулсан ч 12 дугаар сард 371916 төгрөгийн цалингийн зардлыг НДШ-ийн зардлаас гүйлгэж Төрийн санд гүйлгээ хийж зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалт, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан "төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"-тай нийцэхгүй байна.

**3.2. Эрсдэл:** Төсвийн зардлын бүлэгт хооронд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулсан байх.

**3.3. Өгсөн зөвлөмж:** Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан төсвийн зарлагын эдийн засгийн ангиллын дагуу зардлыг бүртгэж, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг хэрэгжүүлж, зардлыг өөр зардлаас зарцуулж гүйлгээ хийдэг явдлыг таслан зогсоох

**3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 07 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо	Аудитын нэр:	Богд сумын Сум дундын эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:		
			БНА-2021/166/СТА-ТШЗ		
Шалгагдсан байгууллагын нэр:		Богд сумын Сум дундын эмнэлэг	Мянган төгрөг		
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Эрүүл мэндийн газраас шилжүүлсэн эм, эмнэлгийн хэрэгслийг санхүүгийн тайланд 2255218 төгрөгөөр дутуу бүртгэсэн.	2255.2	Санхүүгийн тайланд залруулах	Дарга, нягтлан бодогч	А.Цэцэгбадам, М.Түмэнжаргал
2	Эрүүл мэндийн газраас шилжүүлсэн эм, эмнэлгийн хэрэгслийг санхүүгийн тайланд 2255218 төгрөгөөр дутуу бүртгэсэнтэй холбоотой 2255218 төгрөгийн өглөг үүссэнийг санхүүгийн тайланд тусгаагүй.	2255.2	Санхүүгийн тайланд залруулах	Дарга, нягтлан бодогч	А.Цэцэгбадам, М.Түмэнжаргал
3	Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.	-	Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	А.Цэцэгбадам, М.Түмэнжаргал
4	Хүнсний зардлыг анхан шатны баримтаас тулган шалгахад тайлант эцэст 2617.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь нэг сард ногдох зардлаас 3-4 дахин их хүнс нөөцөлсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.	2405.0	Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	А.Цэцэгбадам, М.Түмэнжаргал
5	Цалингийн зардалд 461377,7 мянга, НДШ-ийн зардалд 56403,1 мянган төгрөг зарцуулсан ч 12 дугаар сард 371916 төгрөгийн цалингийн зардлыг НДШ-ийн зардлаас гүйлгэж зарцуулсан байна.	371.9	Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	А.Цэцэгбадам, М.Түмэнжаргал
<b>ДҮН</b>		<b>7287.4</b>			

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

Бэлтгэсэн:

АУДИТОР .....

Ж.ӨСӨХБАЯР  
Огноо: 2021.02.02

Анхан шатанд хянасан:

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН  
МЕНЕЖЕР .....

А.ЦЭЭНЯМ  
Огноо: 2021.02.02

Хоёр дахь шатанд хянасан:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР .....

Б.МӨНХБАТ  
Огноо: 2021.02.02